

**“Монголын төмөр зам” ТӨХК-д
төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн тухай**

Нэг. Хяналт шалгалтын зорилго

Зам, тээврийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/167 дугаар тушаалын дагуу “Монголын төмөр зам” ТӨХК-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтын үр нөлөө, худалдан авах ажиллагаа, түүнчлэн бүтэц, стратегийн өөрчлөлт, хүний нөөцийн зохион байгуулалт болон тэдгээрийн үр нөлөөнд хяналт, шалгалт хийсэн.

Уг хяналт, шалгалтын зорилго нь “Монголын төмөр зам” ТӨХК-ийн санхүү болон бусад холбогдох үйл ажиллагаанд бодит үнэлгээ өгч, компанийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлон, цаашдын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж боловсруулахад оршино.

Хоёр. Хяналт шалгалт хийсэн хугацаа

Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2025 оны 06 дугаар сарын 20-25-ны өдрүүдэд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Гурав. Хяналт шалгалтад хамрагдсан асуудал

Шалгалтад дараах асуудлуудыг хамруулсан. Үүнд:

1. Төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон тэдгээрийг үндэслэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан дүрэм, журам, заавар, стандарт, гэрээний хэрэгжилт;
2. Компанийн зохион байгуулалтын бүтэц;
3. Албан тушаалын жагсаалт;
4. Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөө болон тайлан;
5. Цалин хөлс тогтоолт, бодолт, олголт;
6. Тухайн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтны хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг хариуцлагын биелэлт;
7. Гүйцэтгэх захирлын А болон Б тушаалууд;
8. “Тавантолгой төмөр зам” ХХК-аас шилжин томилогдсон албан хаагчдын мэдээлэл;
9. Бусад.

Дөрөв. Хяналт шалгалтаар тогтоогдсон бодит нөхцөл байдал

Хяналт шалгалтаар нийт 3 зөрчил болон анхаарал татсан 4 дутагдал илрүүлсэн бөгөөд үүний дагуу 5 зөвлөмж боловсруулан хэрэгжүүлэхээр ажилласан. Мөн шалгалтын хүрээнд гарсан дүгнэлтийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажилласан.

Тав. Хяналт шалгалтын явцад авсан арга хэмжээ, зөвлөмж

Дээр дурдсан илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, мөн цаашид ижил төрлийн зөрчил, дутагдал дахин гаргахгүй байх зорилгоор нийт 5 зөвлөмж боловсруулан хүргүүлж ажиллалаа. Үүний дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар чиглэл, заавар өгсөн болно.

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР